



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/208

Бат-Өлзий сум

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын бараа үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг үндэслэн 4 дүгээр багийн нутаг Галт, Гуяын нуруу, 2 дугаар багийн нутаг Билүүтийн хөндлөн, 6 дугаар багийн нутаг Улиастайн дэнжид худаг (цооног) гаргах ажлын тендер (ӨВАБӨСЗДТГ/202301027) –ийг хүчингүй болгосугай.

2. Галт, Гуяын нуруу, 2 дугаар багийн нутаг Билүүтийн хөндлөн, 6 дугаар багийн нутаг Улиастайн дэнжид худаг (цооног) гаргах ажлын тендерийг тендер шалгаруулалтын онцгой журам, харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Дашдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН